



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Одонгийн ЦОГТГЭРЭЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-34-14, Факс: 32-70-16
E-mail: tsogtgerelo@parliament.mn
http://www.parliament.mn

2026.04.14 № 412-03/3867
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 17 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ
О.АЛТАНГЭРЭЛ
Н.АЛТАНХУЯГ
О.АМГАЛАНБААТАР
Ц.БААТАРХҮҮ
Д.БАТБАЯР
Ж.БАТСУУРЬ
Х.БАТТУЛГА
П.БАТЧИМЭГ

2026000061

Ж.БАЯРМАА
Ж.БАЯСГАЛАН
Б.БЕЙСЕН
Х.БОЛОРМАА
Ш.БЯМБАСҮРЭН
А.ГАНБААТАР
Г.ГАНБААТАР
С.ГАНБААТАР
Д.ГАНБАТ
Л.ГАНТӨМӨР
Б.ЖАРГАЛАН
Д.ЖАРГАЛСАЙХАН
Ч.ЛОДОЙСАМБУУ
Ц.МӨНХБАТ
Л.МӨНХБАЯСГАЛАН
П.МӨНХТУЛГА
Ц.МӨНХТУЯА
Э.ОДБАЯР
С.ОДОНТУЯА
Г.ОЧИРБАТ
Б.ПУНСАЛМАА
Б.ПҮРЭВДОРЖ
Р.СЭДДОРЖ
Ц.ТУВААН
Б.ТҮВШИН
Х.ТЭМҮҮЖИН
Г.ХОСБАЯР
Д.ЦОГТБААТАР
С.ЦЭНГҮҮН
Ө.ШИЖИР
Д.ЭНХТУЯА
С.ЭРДЭНЭБОЛД
Р.ЭРДЭНЭБҮРЭН

2026000081



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Одонгийн ЦОГТГЭРЭЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-34-14, Факс: 32-70-16
E-mail: tsogtgerelo@parliament.mn
http://www.parliament.mn

2026. 03. 17 № УИХ-03/2589
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч ба дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох бусад бичиг баримтыг хавсаргав.

Хавсралт ...¹⁷⁷...хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2026000036



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.01.27 № 178/269

танай _____-ны № _____-т


**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт *02* хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 3 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“3.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс санаачлан боловсруулсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс санаачлан боловсруулсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд Төрийн болон албаны нууцын тухай хуулиас “албаны нууц”-д холбогдох зохицуулалтыг бүхэлд нь хасаж, төрийн нууцын жагсаалтыг тухайлсан хуулиар батлахаар, төрийн нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, хугацааг сунгах зэрэг асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэхээр хуулийн төсөл боловсруулсан нь уг хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөөр байна.

Түүнчлэн, хуулийн төслийн хүрээнд албаны нууцад хамаарах зохицуулалтыг хассанаар Төрийн болон албаны нууцын тухай хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3 дахь заалтад тус тус заасны дагуу хуулийн төслийг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулах;

2.Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эрх ашигт учруулж болзошгүй хор хохирлын хэмжээгээр нь үнэлэн гадаад бодлого, үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээллийг албаны нууцад хамааруулдаг тул энэ хүрээнд нууцалсан мэдээллийг ил болгох, эсхүл нууцын зэрэглэл нэмэгдүүлэх талаарх зохицуулалтыг тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд тодорхой тусгах;

3.Төрийн нууцад хамаарах мэдээллийг зөвхөн “маш нууц”, “онц чухал нууц” гэсэн зэрэглэлд хамааруулснаар 20, эсхүл 30 жил нууцлах шаардлага үүсэж байна.

Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Канад Улс, Австралийн Холбооны Улс, Шинэ Зеланд Улс зэрэг хөгжингүй улс орнууд гадаад бодлоготой холбоотой нууц мэдээллийг задруулсан буюу үрэгдүүлсэн тохиолдолд учруулах хор хохирлын хэмжээгээр нь 3-4 зэрэглэлд авч үздэг жишгийг анхаарч, нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоох;


4.Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалтад заасан “Хуулийн төслийн агуулга нь зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх” шаардлагыг хангахгүй байна.

Тухайлбал, хуулийн төслийн үзэл баримтлалд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нууцыг хуулиар тогтоон хамгаалах суурь зарчимд нийцэхгүй талаар дурдсан боловч хуулийн төсөлд эдгээр хэсэгт өөрчлөлт оруулах талаар тусгаагүй, мөн хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нэмэхээр тусгасан 4.3 дахь хэсэг нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардаж байна.

Түүнчлэн, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтад заасан нууцад хамаарах мэдээллийн “нууц” зэрэглэлийг хүчингүй болгохоор тусгасан боловч тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтад тус тус заасан “нууц” зэрэглэлийн зохицуулалт хэвээр байгааг анхаарах;

5.Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж байгаа Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан.

Энэ ажлын хүрээнд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн нэрийг “Төрийн нууцын тухай хууль” болгон өөрчилж, тус хуулиар зөвхөн төрийн нууцтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, албаны нууцтай холбоотой зохицуулалтыг бүхэлд нь хасах, төрийн нууцад хамаарахаас бусад төрийн байгууллагын бүх мэдээлэл ил тод, нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан хүрээнд нийцүүлэн төрийн нууцын жагсаалтыг хуулиар тогтоох буюу төрийн нууцын жагсаалтыг Улсын Их Хурлаас баталж, иргэд, олон нийтийн хяналтыг тогтоох, төрийн нууцад хамааруулах мэдээллийн хүрээ, жагсаалтыг хуульчлахаар холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж, 2026 оны Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганд өргөн мэдүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР